

VIII БОГДЫН ХОЙД ДҮР БА УЛААНТНУУД

Харнууд 3. Лонжид

Товч утга: 1924 оны хавар Монгол улсын төрийн тэргүүн Жибзундамба хутагт таалал болсны дараахнаас эхлээд түүний хойд дүрийг хэвшсэн уламжлалын дагуу тодруулъя хэмээн Нийслэл хүрээний мяндаг тушаалтай лам нар хамтарч төр засагт уламжилсан боловч тодорхой хариу өгөөгүй байх үед Богд хан уулын аймгийн Ноён уулын хошууны Эрдэнэ мандал сумын нэгдүгээр багийн 1-р арваны ард Түдэвийн гэргий Цэнджав гэгч 1925 оны зуны дунд сараас эхлэн элдэв зүйл ярих болжээ. Тухайлбал хэдэн сарын дараа өөрөөс нь нэгэн хөвгүүн төрнө, тэр бол Богд хутагтын хойд дүр юм хэмээн дахин давтан ярьж олны анхаарлыг нилээд татах болсон ба түүнээс хойш долоон сарын дараа тэр бүсгүй амаржиж хүү төрүүлжээ. Үүнээс хойш Цэнджавыг тойрсон олон үйл явдал өрнөсөн нь Монголын нийслэлд сууж байсан ЗХУ-ын бие төлөөлөгчдийн сонорт хүрснийг тэд Москвад мэдээлснээр улаантнууд Богдын хойд дүрийг хэрхэх тухай шил шилээ дарсан олон зүйл хэрэгжүүлснийг энэ өгүүлэлд хураангуй авч үзлээ.

Түлхүүр үг: VIII Богдын хойд дүр, улаантнууд, Цэнджав,

1. Цэнджав олонд алдарших болсны товч

1924 оны намар өвлийн заагаар Богд хааны номын багш Ёнзон хамба түвэд Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин, гавж Ганжуур, Манзушир хутагт Цэрэндорж, цорж Чойнзон тэргүүтэй жараад хүн зөвлөн хэлэлцэж Богд Жибзундамбын шинэ дүрийг тодруулах цаг болсон эсэхийг асууж лавлахаар тусгай хүмүүсийг Лхас руу илгээж, Далай лам, Банчин богд, Саж гэгээнтэн нарт айлтгаж сунтаг шүүлгүүлэхээр шийдвэрлэжээ¹. Гэвч чухам хэн хэнийг хэзээ явуулахаа яг тодорхой товлгоогүй байх үед XVI жарны модон үхэр жилийн зуны дунд (1925-06) сард дээр дурдсан Цэнджавын нөхөр Түдэв хэмээгч мөн хошууны Рашаант сумын Шаварын буюу Хэрэхийн дуганы лам өөрийн танил Гомбо гэлэнгийн ирж манай эхнэр гэнэт ухаан алдаж унадаг болсны сацуу, элдэв зүйл ярьдаг болчихлоо, түүний хэлснээр бол ирэх барс жилийн барс сарын барс өдрийн барс цагт надаас нэгэн хөвгүүн төрнө. Тэр бол өргөн Туулын хөвөөн дээрх өндөр ногоон сүмд байсан бүсгүй язгууртай хүний сүнс юм.

1. УТА.МАН 4-6-82, 5-8, 50-51.

Иймээс тэр хүүг эх барьж авах барс жилтэй хүн, таван өнгийн тамсаг идээ бэлтгэж байцгаа хэмээн үргэлж ярих юм.

Та түүний өвчнийг эдгээх ямар арга тус байгааг мэргэлж өгнө үү хэмээсэнд Гомбо ламтан шоо орхиж үзээд тийм ч сайн ёр шинжгүй байгааг хэлж Очирваань, Далх зэрэг ном уншуул хэмээн хэлж буцаажээ. Гэтэл мөнөөх Түдэв хэд хоногийн дараа дахин ирж, манай эхнэр өөртөө арван могойтой дээл, очиртой шар малгай, нэг талдаа бага нүхтэй хэнгэрэг зэргийг бэлтгэж өг хэмээн нэхэж шаардах боллоо. Өвчин нь ер илааршихгүй байна. Түүний өвчнийг бүрмөсөн эдгээх тус хийж өгөөч хэмээн гуйжээ. Гэвч Гомбо бээр эдгээж чадахгүй хэмээжээ. Түүнээс хойш мөн хэд хоногийн дараа Түдэв бээр гурав дахь удаагаа Гомбо гэлэнгийн ирж би эхнэрийнхээ хэлсний дагуу малгай, дээл, хэнгэрэг зэргийг бэлтгээд авч ирлээ. Та тэднийг аравнайж өгнө үү хэмээснийх нь дагуу зохих зан үйл гүйцэтгэжээ. Түүнээс хойш Цэнджавын заасан цаг хугацаанд буюу XVI жарны гал барс (1926 он) жилийн барс сарын барс эзэлсэн 30-(1926-02-14)-ны үүр цайхын хирд буюу барс цагт тус хошууны Ялбаг хэмээх голын хойд этгээд Хөшөөтийн овооны өвөрт тэрбээр амаржиж хүү төрүүлжээ. Тэр хөвгүүнд Лувсандорж хэмээх нэр өгсөн боловч эх нь миний хүү бол Арын хоёр Богдын нэг байгаа юм хэмээгээд хүүдээ улаан халзан гэр, шантай (алтадсан) ширээ, сэнтий, очир жинстэй малгай зэргийг бэлтгүүлж өгөөд хүүгээ Очирдара, өөрийгөө Мэргэндуурсгал хэмээн нэрлэжээ². Тэр үеэс эхлэн Цэнджав Лувсандорж хоёр бол эгэл бус юм байна хэмээх яриа тэр сумаас эхлэн бараг улс даяар тархжээ. Монголын төр тэр үед Богдын хойд дүр тодруулах эсэх талаар ямарч шийдвэр гаргаагүй байсан учир сүсэгтэн олон, нөлөө бүхий лам хувраг, нам, төрийн албан хаагч, эгэл ард зэрэг нийгмийн янз бүрийн давхрааны олон хүн тэр хүүг шинжин сорьж Богдын хувилгаан мөн аваас ширээнд нь залъя хэмээх болжээ.

Бас Цэнджав бээр хүүгээ төрүүлснээс хойш ямар ч хүний асуусан зүйлийг андахгүй мэддэг сайн төлөгч болсон гэнэ хэмээх яриа олны дунд түргэн тархжээ. Гомбо гэлэн ч үүнийг сонсоод өөрийнхөө өвчнийг Улаанбаатарт очиж эмчлүүлж болох эсэхийг Цэнджаваас асуухаар 1926 оны хаврын дунд сард Түдэвийнд очиж мэргэлүүлсэнд Хүрээ орж эмчлүүлээд тус болохгүй юм байна гэжээ. Гэвч Гомбо бээр түүний үгийг үл хэрэгсэн Нийслэлд очиж хоёр сар эмчлүүлээд нутагтаа очиж өвчнөө бүрэн эдгэсэн эсэхийг Цэнджаваас асуухад өвчин чинь эдгэсэн байна. Харин та өөрийнхөө гэрийг нүүлгэж манайтай айлсах хэрэгтэй. Шашинтай газар төрсөн хүмүүс миний хөвгүүнийг өргөмжилж байваас зохино гэжээ. Гомбо гэлэн Цэнджавын хэлснийг эс зөвшөөрсөнд түүний нөхөр Түдэв бээр мөнөөх ламтанд хандаж чи энэ хүний үгнээс зөрж ер болохгүй. Би хаширсан хүн шүү.

Ноднин жил энэ хүүхэн өөртөө арц буцалгаж өг гэхээр нь би ганга,

2. УТА. 458-1-41,13-20.

агь зэргийг чанаж өгсөнд миний нэг гарыг татуулж нилээд хэд хоногийн дараагаар за чи хаширч залхав уу гээд усаар угааж эдгээсэн юм.

Тэгэхээр чи Цэнджавын үгэнд орж манай гадаа нүүж ир. Тэгээд энэ хүүхэн сахиусаа залахад нь сан тавьж бай хэмээн ятгажээ. Гомбо ламтан Түдэвийн үгийг дагаж тэр жилийн зуны дунд сарын 19-(1926-06-29)-нд нүүж Түдэвийнтэй айлсан буужээ. Тэр өдрөөс эхлэн Цэнджавыг сахиусаа залахад Гомбо гэлэн сан тавьдаг, Түдэв нь эхнэрийнхээ бөөлж байхдаа хэлсэн ярьсан зүйлийг бусдад дамжуулдаг хэлмэрч нь болжээ³.

Цэнджав бээр нэг удаа Богдын хаалгач байсан Ёндон гэгч хүнийг нэр зааж чи Улаанбаатар орж Манзушир ламтан түүний дэргэд байгаа бас нэгэн хүнтэй уулзаж *"нэг настай нялх дүртэй Очирдара ламтан энд хувилсныг сонсгож хадаг бариад ирсүгэй"* хэмээн даалгажээ. (Энэхүү Ёндон бол Богд хан уулын аймгийн Халиугчин Боролзой уулын хошууны уугуул бөгөөд бага наснаасаа эхлэн Нийслэлийн Зүүн хүрээний Эрхэм Тойны аймагт өөрийн дүү Наваан, Гонгор хоёртой хамт сууж VIII Богдын хаалгачийн алба хашиж байгаад 1925 оны эхээр Ерөөгийн сангийн тариаланд зарлагаар ажиллаж тэндэхийн нягтлан бодогч Ээндэн хэмээгчээс Цэнджавын тухай сонсож түүнээс юм асуухаар мөн оны 6-р сард Цэнджавтай уулзаж өөрийгөө асуусанд Сэдэд, Сэдэдийн догжор, Очирваань, Очирваанийн догжор, Алтангэрэл зэргийг уншуул гэжээ. Ёндон бээр үүнийг сонсоод би урьд VIII Богдод бараа болж байлаа, одоо IX Богдод мөргөх хувь байна уу гэж асуужээ. Цэнджав үүний хариуг хэлсэнгүй шууд *"урьд өргөн Туулын хөвөөнд өндөр ногоон сүмд язгууртай байсан хүн одоо ядуу хоосон улаан цусан хүрдийг эргүүлсэн хамниган газарт төрөөд байгаа энэ хүүхдийг өсгөх хүн чамайг гэж байна"* хэмээн хэлснийх нь дагуу Түдэвийн гэрт сууж тэр хөвгүүнийг асрах болжээ.

Үүний маргааш нь Ёндон бээр Улаанбаатар луу явж тэр өдрийнхөө шөнө Хунцал гэдэг газар нутаглаж буй Сандагийнд хоноглож байхад мөнөөх Гомбо гэлэн араас нь ирж намайг чамтай цуг хот орж Манзушир ламтанд хадаг барилц гэв. Сумын дарга Цэвэг олон яамныхантай уулзаж Цэнджав түүний хөвгүүн хоёрын тухай сонсох гэнэ хэмээн ярьжээ. Гомбо, Ёндон хоёр Улаанбаатар орж Ээндэнтэй уулзаж ирсэн учраа ярьсанд тэрбээр та хоёр зайсан Дүвжиртэй хамт гурвуул явж Манзушир, Ёнзон хамба нарт хадаг барь гэжээ. Тэд энэ дагуу мөнөөх хүмүүст хадаг барьж Цэнджавын тухай товч ярьжээ.

Ёнзон хамба тэдний яриаг сонсоод *"за за энэ тухай олноороо хэлэлцэж байгааг би жас (жасын?) ламаас сонссон билээ. Ийм дураараа үгтэй хүнд хэлэх үг алга. Харин эл учрыг Шашны хэрэг эрхлэх газар мэдэгдээрэй"* хэмээн хэлээд нэг хадаг өгчээ.

³ З. УТА.458-1-41, 16-19.

Манзушир ламтан тэр хүүхэн хаана, аль зүгт ямар нэртэй газар байгааг асууж лавлаад *“Богд энд тэнд хувилах магадгүй, гэвч би юу мэдмүй. Харин урьд Эх дагина миний нэг дээлийг өмсөж байгаад би бас сайхан лам болж хэмээгээд над эгүүлэн өгснөөр миний дэргэд байгаа охиныг Эх дагина байх магадгүй хэмээн санадаг боловч Эх дагиныг таалал болсноос хойш зургаан сар болоод төрсөн нь хараахан таардаггүй юм. Тэр хүүхэнтэй уулзъя хэмээсэн боловч тэр эдүгээ уулын ард Тэнгэрийн аманд буй”* хэмээн хэлж нэгэн хадаг өгснөөс өөр юм яриагүй аж.

Ёндон, Гомбо, Дүвжир гурав Ёнзон хамбын хэлсний дагуу Шашны хэрэг эрхлэх газар очиж Цэнджавын тухай мэдэгдээд Гомбо нутаг буцжээ. Ёндон хаалгач хоцорч Манзуширын ярьж байсан охинтой уулзаж нэг хадаг барьсанд тэрбээр хариу хадаг өгөөд ер юм яриагүй гэнэ. Ёндон бээр тэр өдрөө Хүрээ цам үзээд маргааш нь гарч явсаар Ноён уулын хошуу наадам сонирхоод Түдэвийнд очиж хотод хэн хэнтэй уулзаж ямар ажил төрөл гүйцэтгэсэнэ Цэнджавт ярьж хүү Лувсандоржид нь шар торгон дээл, бойтог зэргийг бэлгэлжээ. Тэр үед Цэнджав ярихдаа Ээндэнгийн эхнэр өөрт нь алтан очиртой малгай, хэнгэрэг, цан ширээ зэрэг юм өгсөн гэжээ. Ингээд Цэнджав бээр их элбэг дэлбэг идээ, шүүс, боов бэлтгэх хэрэгтэй. Чухам юу юугаар хэрхэн бэлтгэхийг чи мэд хэмээн Ёндонд даалгажээ.

Ёндон ч энэ дагуу бүх идээ шүүс бэлтгүүлж дууссаны дараа хол ойроос олон хүн цуглаж ирэхэд Цэнджав сахиусаа залж өөрийнхөө болон хүүгийнхээ шинэ нэртэй болсныг зарлаж, хүүгээ гурван нас хүртэл өөрөө хэлмэрч нь болж байх учиртай юм гэх зэргээр ярьсан байна. Үүнээс хойш тэрбээр сахиусаа залсаар байжээ.

2. Улаан Орос мэгдэн сандрав.

1926 оны хавраас эхэлсэн Богдын шинэ дүр тодорсон тухай яриа Монгол даяар тархах болсныг ЗХУ-аас Улаанбаатарт сууж байсан бүрэн эрхт төлөөлөгч П.М.Никифоров сонсож мэдсэнээ 1926 оны тавдугаар сарын 31-ний өдөр өөрийн тэмдэглэлдээ бичсэн байна⁴. Үүний дараа зургадугаар сарын 28-нд Монголын лам нар Богд Хутагтын хойд дүр *“тодруулах зөвшөөрөл өгөхийг хүссэн өргөдөл бичигтээ лам нар нийт хүн амаар гарын үсэг зуруулах бодолтой байна.”*⁵ гэж мөн тэмдэглэлдээ бичсэн байна. Гэвч үнэхээр ийм явдал болсон эсэхийг шууд ба дам нотлох ямар ч сурвалжийг би одоогоор олсонгүй. Гэхдээ нөлөө бүхий хэд хэдэн лам, зарим сүсэгтнүүд Богдын шинэ дүр тодруулахыг хүсэж байсан тухай мэдээ байдгийг өмнө дурдсан. Харин нийт хүн амаар гарын үсэг зуруулсан эсэхийг Никифоров тэмдэглэлдээ дурдсан байх боловч үүнийг нотлохуйц сурвалж одоогоор архивуудын сан хөмрөгөөс олдоогүй байна.

4. XX зууны хориод оны тэмдэглэлүүд. Эмхтгэж хэвлүүлсэн Д.Өлзийбаатар УБ, 2007. т.63

5. Мөн тэнд, т. 70.

Никифоровын дамжуулсан мэдээг авсан Коминтерн, ЗХУ-ын удирдагчид нилээд цочирдож тусгайлан судлуулсан бололтой. Тэр үед МАХН-ы Төв Хороо, Бүх цэргийн зөвлөл, ДХГ-т зөвлөх сургагчаар ажиллаж байсан оросууд дээрээс авсан үүргийнхээ дагуу Богдын хойд дүр тодруулахыг нэн даруй таслан зогсоох шат дараалсан ажил зохион байгуулжээ. Тэгэхдээ юуны өмнө Коминтернээр түрий барьсан нь 1926 оны 9-р сарын 26-нд ажлаа эхэлсэн МАХН-ын V Их хуралд ирүүлсэн албан захидлаас тодорхой мэдэгдэж байна. Тэрхүү захидалд танай улсын зарим хүмүүс “Богд гэгээнийг дахин буй болгох зэргээр оролдож буй ажээ” гэтэл “энэ мэт явдлыг эс гаргуулахын учраа харьяат намаас тухай дор арга хэмжээ зүйлийг эрсэнгүй мэт” иймд цаашдаа “энэ мэтийн урьдын байдлыг хэвээр сэргээхийг үндсээр устгахын аргыг эрүүлэхийг хичээвээс зохино” хэмээн хатуу анхааруулж Богдын хойд дүр тодруулах хэмээсэн хүмүүсийг МАХН эсэргүүцэж няцаахгүй байна хэмээн Коминтерн зэмлэж цаашдаа аливаа хутагт, хувилгаадын дүр тодруулахыг бүрмөсөн хориглохыг шаардсан байна. Коминтерны энэ захидлын гол агуулгыг ухаарч ойлгосон тус хурлын төлөөлөгчид олон жилийн уламжлалаа хэвээр хадгалж Богдын шинэ дүр тодруулахыг цаашид үргэлжлүүлэх нь зөв хэмээн нилээд хүн санал бодлоо илэрхийлсэн бололтой. Жишээлбэл, эрдэмтэн Ж.Цэвээн тус их хурлын 9-р сарын 30-ны өдрийн 5-р хуралдаан дээр “манай их хурал хэдэн өдөр Цэнджавын тухай ярилаа” гэж цохон тэмдэглэснээс тодорхой байна. Гэтэл тэдгээр хүмүүсийн хэлсэн үгийг тус хурлын протоколоос хасаж устгасан буюу эсвэл хожим ноцтой хэргийн баримт болгохоор ЗХУ-д аваачсан байж магадгүй аж. Ямар ч байсан Монгол улсын нээлттэй архивуудаас тэдгээр хүмүүсийн хэлсэн үг олдохгүй байна.

Тус хурал дээр Богдын шинэ дүрийн тухай олон төлөөлөгч ярих болсонд хурлын үйл ажиллагааг хянаж байсан ЗХУ, Коминтерны төлөөлөгчид сандарч МАХН-ын ТХ-ны тэргүүн дарга Ц.Дамбадоржид тусгай даалгавар өгч Богдын дүр дахин тодруулахыг хориглосон шийдвэр тус хурлаас гарга хэмээн тулган шаардсан бололтой. Тиймээс ч тэрбээр тус их хурал дээр үг хэлж Цэнджав хэмээх бүсгүйг “Богдын дэргэд бараа болж агсан харгис лам нараас хатган зааварлаж” түүнээс төрсөн хөвгүүнийг Богдын хойд дүр хэмээн “хэрэг дэгдээсээр байна. Хэрэв Богдын дүрийг тодруулбал шар харгисын хүчнийг улам зузаатгахаас бус ард олныг амаржуулан туслах тустай зүйл гарахгүй буйза.” Иймээс цаашид “хутагт хувилгаадыг тодруулах” эсэхийг “нэгэн тийш болгож тус хурлаас тогтоол гаргахыг хүснэ” гэжээ.

Ц.Дамбадорж бээр ийм эрс огцом санал гаргасан нь анхаарал татаж байна.

6. МАХН-ын V их хурал. 1926 оны есдүгээр сарын 26-аас аравдугаар сарын 3. Дэлгэрэнгүй тайлан. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Б.Цэдэн, З. Лонжид УБ.1981. т.13.

7. Мөн тэнд, т.122.

8. Мөн тэнд, т.122.

Яагаад гэвэл тэрбээр нам төрийн үндсэн үүрэг, эрх хэмжээ, хариуцах ёстой ажлын зааг ялгаа болон төр шашны хэрэг тусдаа гэдгийг сайн мэдэх өндөр албан тушаалтан атлаа ийм үг хэлсэн учир бол тэрбээр оросуудын шахалтад автсаных бололтой. Тус их хурлын төлөөлөгчид Дамбадоржийн саналыг эсэргүүцсэн аж.

Тухайлбал Жадамба бээр “хутагт хувилгаадын хойд дүрийг залах, залахгүй гэх нь хараахан эртэдсэн” хэрэг болох учраас “эрхгүй олны саналыг харгалзах хэрэгтэй” гэж хэлжээ. Энэ дагуу “тусгай комисс байгуулж Богдын хойд дүрийг залах эсэхийг хэрхэн шийдвэрлэх” (МАХН.203) -ийг тогтоо гэжээ. Гэтэл тус комиссын гишүүд “Богдын хойд дүрийг залахгүй хэмээн тогтоол гаргаваас олны санал алдагдах болуужин хэмээн зүйл зүйлээр эргэлзэж хэрхэх тухайг шийдвэрлэн төлөвлөж чадаагүй¹⁰” гэдгээ тус хуралд илтгээд нухацтай хэлэлцэхийг санал болгожээ. Жадамбын гаргасан энэ саналын дагууд олон хүн байр сууриа илэрхийлсний дотор эмэгтэй төлөөлөгч Дарьханд “Богд Жибзундамба хутагт болбаас анх үеэс эхлэн одоо VIII дүрийг хүртэл бидний олон ардад тустайгаар явсан ихээхэн лам болох төдийгүй Хятадын эрх мэдлээс ангижирч Ардын Нам ба Засгийг байгуулах хэрэгт оролцож тамгатай бичиг зэргийг өгч нөхөр Сүхбаатар нарыг Холбоот Улсад одуулсан зэрэг зүйлийг үзвээс бидэнд нөхөр Сүхбаатар ба Богд Жибзундамба хутагт нар онц тус хүргэсэн гавьяатай... Иймд Богд Жибзундамба хутагтын хойд дүрийг тодруулах нь зүйтэй болов уу¹¹” гэжээ. Зарим төлөөлөгч Богдын дүрийг тодруулдаг уламжлалаа хэвээр хадгалъя. Тэгэхдээ тодорсон тэр хүүхдээ нялх балчир байхад нь бус насанд хүрэхээр нь ширээнд залж байя хэмээн санал гаргасан байна¹².

Эрдэмтэн Ж. Цэвээн дахин үг хэлэхдээ Жибзундамба хутагтын тухай нилээд тогтож ярьжээ. Тухайлбал VIII Богд бол “шашин төр хоёрыг хослон барина гэсэн түүх буй учраа Гадаад Монголыг Хятадын мэдлээс гаргаж... Монгол улсыг байгуулсан нь манай ардын засаг төрийг мандуулахын үүсгэл суурийг тавьсан нь их гавьяа буй ажээ. VIII дүрийн үе болбаас сүүлийн дүр мөн болох бөгөөд дараа төрөл нь Шамбалд заларч цэргийн жанжсин болно гэх лүндэн агсныг олон бүгдээр мэднэ... Ер хувилгаан хутагт нарын тухай манай олон гишүүд шүүмжлэн хэлэлцэх болбаас маш болгоомжлон хянаж хэлэлцвээс зохино. Хөнгөнөөр аваачиж үл болно... Энэ цагийн байдалд нийлүүлэн хянаваас ер хувилгаан хутагт нар хэмээн нялх хүүхдийг өргөмжилснөөр шашин, төр, үндэсний гурван явдалд хир зэрэг тустай болох вэ?... Богд Жибзундамба хутагтын тухай явдлыг манай мэтийн бэртэгчин ард мунхаг оюунаар таслан шийтгэхэд бэрх тул эрхбиш Далай лам мэтийн дээд газраас лавлаваас зүйтэй болов уу¹³” гэжээ.

9. Мөн тэнд, т.129.

10. Мөн тэнд, т.203.

11. Мөн тэнд, т.204.

12. Мөн тэнд, т.204.

13. Мөн тэнд, т.207.

Түүний энэ саналыг тус их хурал дэмжиж *“бидний бэртэгчин олон шавь нар махан нүд, мунхаг оюунаар магадлан шийтгээж үл чадах учир далай ламд айлтгаж лавлахыг”¹⁴* шинэ сонгогдох Төв хороонд даалгая хэмээн шийдвэрлэжээ.

Богдын дүрийг тодруулах эсэх тухай олон төлөөлөгч ярьсан боловч МАХН-ын Их хурлаас тодорхой шийдвэр гаргавал намаас шашны дотоод асуудалд шууд оролцож хууль зөрчих нь илэрхий байлаа.

Иймээс намын V их хурал Богдын хувилгааныг тодруулах эсэхийг Далай лам тэргүүтнээс лавлаж эцсийн шийдвэр гаргуулъя хэмээн чармайсан нь илэрхий бөгөөд энэ ч үр дүнд хүрснээр тус их хурал *“бидний бэртэгчин олон шавь нар махан нүд, мунхаг оюунаар магадлан шийтгээж үл чадах учир Далай ламд айлтгаж лавлахыг”¹⁵* шинэ сонгогдох Төв Хороонд даалгая хэмээснээс тодорхой байна.

МАХН-ын тус их хурлын энэ шийдвэрийг мөн оны эцсээр хуралдсан БНМАУ-ын III их хурал зөвшөөрч Жибзундамбын шинэ дүр залах эсэхийг *“Далай ламд айлтгаж лавлахаар явуулсан зүйтэй болжээ.”¹⁶* хэмээн 1926 оны 11-р сарын 13-ны тогтоолдоо тэмдэглэжээ.

Гэвч энэ нь чухамдаа бол өргөн олны шаардлагыг түр зуур зогсоох хэмээсэн арга мэх байлаа гэхэд хэтрүүлэл болохгүй мэт. Тус их хурлын дараахан 1926 оны X сарын 29-нд Монгол улсын Засгийн газраас бүх ард түмэнд хандсан 51 нүүр бүхий том хэмжээний ухуулах бичиг хэвлэж улсын хэмжээний бүх сум, албан газар, хүрээ хийдүүдэд тараажээ. Тэрхүү ухуулгад Цэнджавын тухай онцлон тэмдэглэж *“олон ардыг элдвээр хуурмаглан мэхэлж өргөл, мандлыг хүлээн авах буюу аврал гүрэм буулгах зэргээр мөлжин ашиглаж...дэмий балай чалчин буй”¹⁷* хэмээн зэмлэсэн атлаа Богдын шинэ дүр тодруулах эсэх тухай, нам төрөөс энэ талаар чухам ямар байр суурьтай байгааг огт дурдаагүй байв. Улаан оросууд Богдын хойд дүр тодруулж болохгүйг Монголын эрх баригчдад шууд тулгаж олон янзын тактик хэрэглэсний нэг нь төрийн хүчирхийлэл буюу шорон гяндангаар сүрдүүлснийг ард өгүүлнэ.

3. Дотоодыг хамгаалах газар ба Цэнджав

Цэнджав Лувсандорж хоёрын тухай яриа ихээхэн тархсан тэр үед өргөн олон IX Богдыг тодруулан залахыг нам, төрөөс шаардах болжээ. Иймд 1926 оны зун Шашны хэрэг эрхлэх газраас Засгийн газарт 16 тоот бичиг өргөн толилуулж, Жибзундамбын хойд дүрийг тодруулан залж тахихыг өргөн

14. Мөн тэнд.

15. Мөн тэнд.

16. БНМАУ-ын Их бага Хурлын тогтоол, Үндсэн хууль тунхагууд. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Ц. Насанбалжир УБ. 1956, т. 57.

17. БНМАУ-ын Засгийн газраас тус улсын харьяат шар, хар, эрэгтэй, эмэгтэй олон түмэн ардуудад нийтээр сэнхрүүлэн ухуулах бичиг УБ. 1926. т. 38-39.

олон хүсэж байна, хэрхэх вэ? хэмээн лавлажээ. Тэгэхдээ тэрхүү бичигт Лувсандоржийн тухай огт дурдаагүй байна¹⁸. Ерөнхий сайд Цэрэндорж үүнийг МАХН-ын Төв Хороонд мэдэгдэж, мөн оны 7-р сарын 16-нд 149 тоотгоор уламжилж хариу хүсчээ.

НТХ энэ бичгийн хариу өгч завдаагүй байхад буюу мөн оны 8-р сарын 16-нд Ерөнхийн сайдаас дахин НТХ-д бичиг хүргүүлж, ДХГ-аас Цэнджавын тухай мэдээлснийг товч дурдаад хэрхэн болговоос зохихыг заана уу гэжээ¹⁹. Гэвч НТХ мөн хариу өгөөгүй байхад 8-р сарын 17-нд Цэрэндоржоос НТХ-д яаралтай мэдэгдэж Шашны хэрэг эрхлэх газар бидэнд бичиг ирүүлж одоо Лхас руу одох сайд түшмэдэд даалгаж, Богдын гонзог, буян үйлдүүлэх түүний хувилгааныг хэрхэн тодруулахыг асуулгаж болох эсэх тухай лавлаж байна. Зохих хариу өгнө үү гэжээ²⁰. Засгийн газраас хэд хэдэн удаа ирүүлсэн эдгээр бичигт НТХ хариу өгсөн эсэх нь одоогоор нотлогдохгүй байна. Ямар ч байсан НТХ-ноос тэрхүү Цэнджавыг сайн тагнаж бай хэмээн даалгасан бололтой. Тиймээс ч ДХГ Цэнджавыг сэм тагнаж түүнтэй холбогдох нилээд мэдээ цуглуулжээ.

Тэдгээр мэдээнээс үзвэл, Цэнджав бээр 1926 оны 9-р сарын 12 буюу улаан барс жилийн намрын дунд сарын шинийн тавны өдөр хөвгүүндээ мөргөх цаг болсон хэмээн зарлаж, хамгийн түрүүнд Гомбо гэлэн, нөхөр Түдэв, хадмын талынхаа төрөл өвгөн гэгцэл Балжинням нарыг дараа нь бусад хүмүүсийг мөргүүлж хүүдээ мандал өргүүлсэн байна. Энэ мөргөл ёслолд очсон сүсэгтнүүд 4-5 морь, 2-3 үнээ, 400 төгрөг өргөжээ. Цэнджав бээр сахиусаа залж байхдаа өөрийн хөвгүүнээ “эгэл хүн бус Богдын хойд дүр байгаа юм, удахгүй урд зүгээс олон цэрэгтэй лам ирнэ. Хүүг минь туулай жил Хүрээнд зална” гэх зэргээр ярьж байжээ. Үүнээс хойш сар бүрийн шинийн есөнд тахил өргөж сахиусаа залж “*туулай жилд Жибзундамба хутагтыг залах ба халхын хамаг амьтны жаргал ирмүй. Миний хүү Богдын хойд дүр мөн эсэхийг Банчин Эрдэнээс сунтуг шүүлгээж мэднэ буй за хэмээх буюу*” энэ зуны сүүл сарын аравдаар Маймаа хотын зүгээс 8 түмэн цэрэгтэй, 84 баатартай нарийн хар сахалтай намхан бор лам намайг харсаар нахилзаж тахилзан ирвэл яах билээ. Тэр хүн бол Банчин Богд бөгөөд түүнийг ирснээс хойш халхын хоол бага хорогдоно, цалин иддэг хүмүүс зогсмой” гэх зэргээр байнга ярьж байжээ. Цэнджав янз бүрийн зүйл ярьж сахиусаа тогтмол залахаас гадна хүмүүсийг зохион байгуулж хүүгийнхээ төрсөн нутгийн ойролцоох Бөөрт хэмээх уулын орой дээр овоо босгуулан тахих болсон байна.

ДХГ нилээд хугацаанд Цэнджавын тухай зэгсэн мэдээ цуглуулсан атлаа тэрбээр чухам яг хэзээ юуны тухай мэргэлж хэрхэн мэдсэнийг тодруулж

18. УТА, МАН 4-2-42, т.35.

19. УТА, МАН 4-2-42, т.9, 4-2-162, т.7.

20. УТА, МАН 4-2-42, т.50а.

чадаагүй аж. Гэхдээ олон хүн түүнийг цаг үргэлж мэргэн хэмээн ярих болж зүг зүгээс хүмүүс түүнтэй уулзахаар байнга ирдгийг ажигласаар байжээ. Үүнээс гадна Лувсандоржийн төрсөн овооны өвөрт Манагад (?) сэцэн оршдог ба Ягшас оршуулсан газар гэнэ хэмээх цуу яриа нилээд тархсаныг мэдэж авчээ.

Ийнхүү ДХГ мэдээ цуглуулж байх явцдаа 1926 оны 8-р сарын эхээр Монголын Засгийн Газарт Цэнджавын тухай уламжилсанд Ерөнхий сайд Цэрэндорж бээр мөн сарын 16-нд МАХН-ы Төв Хорооноо 158 тоотоор мэдэгдэж цаашид хэрхэхийг лавлажээ.

МАХН-ын Төв Хороо зохих шийдвэр гаргасны дагуу мөн оны 10-р сарын 17-нд ДХГ 45 настай Гомбо, 40 настай Ёндон, 59 настай Балжинням нарыг баривчилж удтал мөрдөн байцаагаад энэ гурван хүн бол зөвхөн Цэнджавын үгийг л дагалдаж байснаас бус өөрсдөө хэрэг өдүүлээгүй байна. Харин Цэнджав олныг мунхруулагч болох учир *“яхин болгох явдлыг зааму”* хэмээн Засгийн Газраас лавлажээ. Засгийн Газар үүнийг 1926 оны 11-р сарын 19-нд МАХН-ы Төв Хороонд уламжилсанд уул хэргийг нэн даруй шийдвэрлэ хэмээсэн хариу өгсөний дагуу мөн оны 12-р сарын 1-нд Засгийн Газрын Эрхлэх товчооны хурлаар Гомбо, Ёндон, Балжинням нарын өчиг мэдүүлэгтэй танилцаад хэргийн гол эзэн Цэнджавыг баривчил. Ёндон, Гомбо, Балжинням гурвыг дахин сайтар байцааж *“чухам үнэн өчгийг гаргуулан авч”* танилцуул хэмээн ДХГ-т даалгажээ. ДХГ энэ шийдвэрийн ёсоор мөнөөх гурван хүнийг дахин байцаасан боловч урьдын өгсөн өчиг мэдүүлгээ өөрчлөөгүй аж. Харин Цэнджав бээр урьд адил элдэв янзын зан үйл үйлдэхээ больсоны сацуу мэргэ төлөг тавихаа зогсож хэвийн болсон байжээ²¹. Мөн хол ойроос Цэнджавын ирж сүсэглэдэг хүмүүс ч байхгүй болжээ. Иймд Цэнджавыг баривчлахаа түр азнаж тасралтгүй тагнаж байхад болох эсэхийг ДХГ 1927 оны 1-р сарын 28-нд Засгийн Газраас лавлажээ. Засгийн Газар мөн оны 2-р сарын 8, 10-нд хоёр удаа НТХ-д бичиг хүргүүлж ДХГ-ын саналыг уламжилсны сацуу Гомбо нарын хэргийг Цаг зуурын шүүх таслах газрын (цаашид ЦЗШТГ гэж товчилно) хурлаар эцэслэн шийдвэрлүүлэх саналтай байгаагаа мэдэгджээ.

Гэвч НТХ ямарч хариу өгөлгүй нилээд хугацаа өнгөрөхөд шоронд хоригдож байсан гурван сэжигтний нэг Балжиннямын эрүүл мэнд доройтсон аж. Иймээс тэрбээр мөн оны 2-р сарын 25-нд ДХГ-т өргөдөл бичиж Гомбо, Ёндон нартай цуг баривчлагдан ирж шоронд 5 сар шахам байцаагдаж бүх үнэнээ өчиж мэдүүлснээ дурдаад *“би мэргэн хүүхэнтэй холбоотой зүйлийг огт мэдэхгүй, иймд мянган нүдэт түмэн сонорт гэгээн төр толилж...ардын энэрэлт гэгээн засгийн нигүүлсэхүй их өршөөлийг хүртээн хүмүүжүүлэхийг эрэн эрэн гуйсугай”*²² хэмээн учирлаж байжээ.

21. УТА, МАН 4-2-336, 1.

22. УТА.458-1-41, 40.

ДХГ Балжиннямьн энэ өргөдөлд хариу өгөөгүй бололтой. Гэхдээ Засгийн Газар энэ тухай уламжилсан байж магадгүй байна. Тиймээс ч ерөнхий сайд бээр 1927 оны 3-р сарын найманд НТХ-нд дахин бичиг өргөж Цэнджавыг баривчлан байцаахгүйгээр үргэлжлүүлэн тагнаж байя.

Харин сэжигтэн Гомбо нарын хэрэг хүнд ноцтой учир тэднийг шүүхийн хаалттай хурлаар хэлэлцүүлэх саналтайгаа уламжилжээ. Гэвч НТХ хариу өгсөн эсэх нь тодорхойгүй аж. Ямарч байсан Гомбо нарыг анх баривчилсан 1926 оны 10-р сарын 17-ноос хойш бараг таван сарын дараа 1927 оны 3-р сарын 14-нд ЦЗШТГ-ын хаалттай хурлаар Гомбо, Ёндон, Балжинням нарын хэргийг хэлэлцэж тэднийг хоёр жилийн хугацаанд Улаанбаатар хотоос гарах эрхгүйгээр байнга суух ял ногдуулж Засгийн Газарт уламжилсанд 3-р сарын 25-нд эцсийн шийдвэр гарч уг ёсоор болгожээ²³.

Үүний дараа ДХГ Гомбо нарыг 3-р сарын 31-нд шоронгоос гаргаж Хан Хэнтий уулын аймгийн Ахай гүнгийн хошууны уугуул бөгөөд Улаанбаатар хотын Зүүн Хүрээний Шүтээний аймагт байнга суудаг лам Лувсанцэрэнг дуудан аваачиж Гомбо гэлэнг хариуцаж бай хэмээн даалгаж өгсөн ба Богд хан уулын аймгийн Гүнцэлцавчид уулын хошууны уугуул бөгөөд Цагдан сэргийлэх газарт явган цагдаа албатай Жамьянсүрэнд Балжинням ламыг мөн хариуцуулж өгөөд хоёр жилийн турш Улаанбаатараас гадагш гаргахгүй харгалзаж бай. Алдаж осолдвол ялтай хэмээн хариуцуулжээ. Харин Ёндон хаалгачийг хэнээр харгалзуулсныг би энэ удаа тодруулж чадсангүй.

4. Гомбо, Балжинням нар оргосны учир

Мөнөөх ялтангууд Улаанбаатар хотод гол төлөв танил айлуудаараа хэсүүлэн толгой хоргодож ямар ч ажил эрхлэлгүй нэг бүтэн сар гаруй болсны дараа 1927 оны 4-р сарын эцсээр Гомбо Балжинням хоёр Улаанбаатараас сэмхэн гарч нутагтаа дөнгөж очоод байхад нь ДХГ тэднийг баривчилжээ. Ингээд ял зөрчиж оргосон тэр хоёрыг харгалзаж байсан Лувсанцэрэн, Жамьянсүрэн нар ба оргосон хүмүүст уналга хөсөг тусалсан байж магадгүй хэмээн сэжиглэсэн Цэвэг зэрэг хэд хэдэн хүнийг ДХГ баривчилж Гомбо, Балжинням, Цэвэг нарыг шоронд хорьж бусдыг нь гадуур байлгаж 5-р сарын 22-оос эхлэн мөрдөн байцааж Лувсанцэрэн Жамьянсүрэн нар ажилдаа хариуцлагаггүй хандсанаас бус санаатай хэрэг үйлдээгүйг нотолжээ. Харин Балжинням Гомбо хоёр эрүүл мэндээ эрс доройтоход Ерөөгийн Рашаанд биеэ сувилахаар хотоос гарч яваад буцаж ирвэл болох эсэхийг ДХГ-ын ажилтан Доржпалам нараас асуусанд эс зөвшөөрсөн учир оргосон гэдгээ хүлээжээ. Тэд үүнээс өөр ямар ч хэрэг үйлдээгүйг нь ч нотлосон байна. Гомбо, Балжинням нарын оршин суудаг сумын дарга Цэвэг бээр хотод ирээд байхдаа тэр хоёрын хүссэний дагуу танил хүмүүст нь унаа залгуул хэмээн

23. УТА, МАН 4-2-336.

хэл хүргүүлснээ буруутай хэмээн мэдүүлсний сацуу ДХГ-аас өөрийг нь дуудан аваачихаар очсон цагдаа Шижиртэй анх уулзахдаа би таны зорьж яваа тэр хүн чинь биш хэмээн булзсан минь үнэн хэмээн шударгаар өчжээ.

Гомбо, Балжинням болон тэдний хэрэгт сэжиглэсэн хүмүүсийг мөрдөн байцааж дууссан боловч шоронд үргэлжлүүлэн хорьж байх үед Гомбо бээр хүндээр өвчлөхөөр нь ДХГ түүнийг Ардын Эрүүлийг Хамгаалах газарт мэдэгдэж түвд эмнэлэгт үзүүлэхэд хүнд өвчин тусчээ хэмээн оношилж хэвтүүлэн эмчилсэн боловч ер илааршихгүй байсаар мөн оны 7-р сарын 3-ны шөнө бие барсныг тус эмнэлэгээс ДХГ-т мэдэгджээ.

Би бээр Гомбо гэлэн чухам хэзээнээс эхлэн өвчилсөн ба өвчнийх нь онош, үхлийн чухам шалтгаан, талийгаачийн шарилыг задлан шинжилж эмнэлгийн дүгнэлт гаргасан эсэх, хэн, хэзээ, хаана оршуулсан зэргийг тодруулахаар баримт сурвалж эрж хайгаад ямарч зүйл олсонгүй. Нэхэн эргэцүүлэхэд, Тагнуулын Ерөнхий Газрын Архиваас эдгээр баримт олдож магадгүйг тэмдэглэе.

ДХГ Балжинням болон бусад сэжигтнийг мөрдөн байцааж дууссаны дараа 6-р сарын дундуур Засгийн Газар мэдэгдсэнийг мөн сарын 22-нд Эрхлэх товчооны хурлаар хэлэлцэж ЦЗШТГ-ын хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэжээ. Энэ дагуу мөн оны 8-р сарын 4-нд ЦЗШТГ-ын дарга Гүрсэд, гишүүн Дэлгэрсан, Цогтцэмбэл нар хуралдаж харгалзах үүргээ биелүүлээгүй 22 настай цагдаа Жамьянсүрэн, 66 настай лам Лувсанцэрэн нарыг тус бүр 25 төгрөгөөр торгож, сумын дарга Цэвэг үйлдсэн хэргээ шударгаар хүлээсэн учир 3 жил нутгаасаа гарах эрхийг нь хасаж шийтгэжээ. Балжиннямыг 150 төгрөгөөр торгож 1 жил 9 сарын туршид Улаанбаатараас гадагш гаргах эрхгүй болгон тэнсэн харгалзахаар шийдвэрлэжээ.

5. Улаантны даалгавраар Монголоос Лхас руу дипломат төлөөлөгч илгээсэн нь

1926 оны намар Монголын Засгийн газар бүрэн эрхт төлөөлөгчөө Лхас руу илгээсэн нь Богдын хойд дүр тодруулах, эсэхэд шууд хамааралтай байлаа. Тиймээс энэ талаар хураангуй өгүүлье.

Зарим түүхч Монголын Засгийн газар өөрийнхөө санаачилгаар түшмэл Гомбо-Идшинг тус улсаас Түвэдэд суух элчин төлөөлөгчөөр томилон одуулжээ хэмээн бичдэг. Гэвч чухамдаа бол ЗХУ-ын удирдагчид Түвэдийн дотоод байдал ялангуяа Далай лам Москвад хэрхэн хандаж буйг байнга хянаж ажиглах, улмаар Түвэдийн эрх баригчдыг Англитай сөргөлдүүлж өөртөө татах зорилгоор монголын элчин төлөөлөгчийг Лхаст суулгаж нөлөө бүхий хүмүүсийг Монгол улсын дипломат ажилтны дүрээр тэнд ажиллуулахыг нэн чухалчилж байжээ. Тиймээс ч 1925 оны 8-р сарын 20-нд ЗХУ-ын Гадаад хэргийн Ардын Комиссариатын Дорнод хэлтэст Далай

ламын бие төлөөлөгч А.Доржиевийг хүлээн авч ярилцахдаа ЗХУ-аас Монголд суух бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон П.М.Никифоровыг байцуулжээ. Тэгэхэд *“Доржиев бээр Далай лам ЗСБНХУ-тай ойртохыг бодож байгаа бодловч англичуудаас айгаад байгаа юм байна”²⁴* хэмээжээ. Үүнээс 4 хоногийн дараа Никифоров бээр Доржиевтэй тусгайлан уулзаж ярилцахад тэрбээр *“би англичууд ямар ч муу юм хийхээс буцахгүй гэдгээс айж байна. Одоо Түвэдэд юу болж байгааг мэдэхгүй байна”²⁵* гэжээ. Эдгээр мэдээг эргэцүүлэхэд тухайн үед ЗХУ Түвэдийн талаар тун анхаарч байсан нь тодорхой аж. Тиймээс ч Никифоровт тусгай даалгавар өгч Монгол Түвэдийн хооронд бүрэн эрхт төлөөлөгчийн хэмжээний дипломат харилцаа тогтоолго. Энэ талаар гарах зардлыг зохих хувийг Зөвлөлт холбоот улс төлөх болно хэмээн мэдэгдсэн бодлолтой. Энэ дагуу Никифоров 1926 оны 10-р сарын 1-нд Ерөнхий сайд Б.Цэрэндоржтой уулзаж *“Түвэд Монгол 2 улс хоорондоо найрамдлын холбоо байгуулах цаг болсон тул Засгийн газраас бүрэн эрхтэй элчин явуулахыг манай Засгийн Газраас эрмэлзэн буй”* гэж албан ёсоор мэдэгджээ. Б.Цэрэндорж бээр үүнийг сонсоод би Засгийн газрын хурлаар хэлэлцүүлээд танд илтгэе хэмээн хариулж улмаар түүний саналыг Намын Төв Хороонд танилцуулан зөвшөөрүүлснээ 7 хоногийн дараа 10-р сарын 8-нд Никифоровт мэдэгдсэн аж. Тэгэхдээ тэрбээр монголоос Лхаст төлөөлөгч суулгаж болох юм, гэвч тэнд хийгээд байх их ажил байхгүй гэлээ гэхдээ Түвэдэд төлөөлөгчтэй байх нь зүгээр юм гэжээ²⁶. Харин Никифоров Түвэд рүү явах төлөөлөгчдийг хэзээ яюуулах хугацаагаа нэн даруй шийдэх хэрэгтэй хэмээхэд Ерөнхий сайд бээр замын зардал маш их болж байгааг ярьжээ. Маргааш нь Никифоров гадаад яамны сайд Гиваабалжирын хамт Цэрэндоржтой уулзаж Түвэд рүү явах төлөөлөгчдийн зардлын талыг Москва даах болно харин ЗХУ *“зөвлөх маягаар нэг хүн оролцуулах болно”* гэж мэдэгджээ²⁷. Энд дурдсан мэдээнээс үзэхэд ЗХУ-аас Түвэдэд нөлөөгөө тогтоохын тулд Монголын дипломат төлөөлөгчийн газрыг Лхаст байгуулахад онцгой анхаарч тусгай төлөвлөгөө боловсруулан Никифоровоор дамжуулан хэрэгжүүлэхийг хичээсэн нь тодорхой байна. Гэтэл Монголын тал ялангуяа Цэрэндорж бээр Монгол Түвэдийн хооронд дипломат харилцаа тогтоох нь манай улсад төдий л ашигтай бус харин ч Хятад, Англитай сөргөлдөхөд хүрч болзошгүйг ухаарч байсан байж магадгүй. Гэвч Зөвлөлтийн тал тулган шаардсаныг арга буюу зөвшөөрч элчин төлөөлөгчөө Лхас руу илгээх болжээ. Энэ мэдээг Москвад авмагц 1927 оны 1-р сарын сүүлчээр БХК(Б)Н-ын Төв хорооны улс төрийн товчоо *“ойрын үед Лхаст БНМАУ-ын төлөөлөгчийн байдлаар ЗСБНХУ-ын албан ёсны бус төлөөлөгчийн хэсгийг явуулах тухай*

24. XX зууны хориод оны тэмдэглэлүүд. Эмхтгэж хэвлүүлсэн Д.Өлзийбаатар УБ, 2007.

т.26.

25. Мөн тэнд.

26. Мөн тэнд, т.25.

27. Мөн тэнд, т. 25, 134

ГХАК-ын саналыг баталжээ²⁸” Энэ дагуу зохих бэлтгэл хангасны дараа 1926 оны намар Монголоос Түвэдэд элчингээр томилсон Гомбо-Идшин, түүний нарийн бичгийн даргад Амгаланг, зөвлөхөд Чагчаев, Раш, М.Т.Бямбаев, Ишдорж зэрэг ЗХУ-ын харьяат халимаг торгууд хүмүүс, ажилтнаар Пунцагбалжир нарыг Лхас руу илгээхдээ Улаанбаатар хотын лам нарын 30 аймгийн Зоогай аймгийн шар зайсан лам Гэндэнсономыг мөргөлчний дүрээр тэдэнтэй хамт явуулжээ. ЗХУ-ын харьяат нар бол Түвэдэд улааны буюу хувьсгалын үзэл дэлгэрүүлэхийн сацуу Гомбо-Идшинд зөвлөх нэрээр түүний бүх үйл ажиллагааг хянаж, зааварлах үүрэгтэй байв. Үүнийг мэдсэн Гомбо-Идшин, Гэндэнсоном хоёр нөгөөх халимаг торгуудуудаас нууцаар Лувсандорж хөвгүүн Богдын хувилгаан мөн эсэхийг Түвэдийн шашны ихэс дээдсээс асууж сунтуг шүүлгэх нууц даалгавартай байжээ.

Гомбо-Идшин, Гэндэнсоном нар Түвэдэд хүрч маш нууцаар Далай лам, Банчин Богд, Саж гэгээн нарт бараалхаж уулзаж Лувсандоржийн тухай лавлаж, сунтуг шүүлгэхэд *“Тэр хөвгүүн мөн боловч залахад саатал тун их байна хэмээн сунтуг бичиж тэмдэг дарж өгснийг авч ирээд 1928 оны хавар Шашны захиргааны газар өгсөн ба Гомбо-Идшин Засгийн газар, НТХ-д танилцуулжээ”*²⁹. Гэвч үүнээс хойш Монголын удирдагчид Богдын хойд дүр тодруулах талаар ямар үйл ажиллагаа явуулсныг тодруулах сурвалж одоогоор олдохгүй байна. Харин В.Жамсранжавын дуртгалдаа өгүүлснээр бол 1928 оны намар ДХГ Богдын хойд дүр тодруулан залах хэрэг үүсгэн сэдэхийг санаачлан удирдсан хэргээр гуч гаруй гавж, гүн Гомбо-Идшин, зайсан Гэндэнсоном нарыг баривчилж, мөрдөн байцааж байгаад эцэст нь хоёр гавж, Гэндэнсоном, Гомбо-Идшин нарт хэдэн сар хорих ял ногдуулж бусдыг нь сулласан аж³⁰. Би энэ удаа эдгээр хэрэгтний хавтаст хэрэгтэй хараахан танилцаж амжсангүйгээ өчье. Ямар ч байсан оросуудын тулгалтаар эхэлсэн зүүнтний их хийрхэл ид эрчээ авсан 1929 оны 1-р сарын 14-ний өдөр Улсын V их хурлаас баталсан тогтоолд “Богд зэрэг хутагт хувилгаадыг залах, тодруулах гэдгийг бүрмөсөн зогсоох³¹” хэрэгтэй гэж заасан юм. Ийнхүү Улаантны тулгалтаар Монголын төрийн эрхийг булааж авсан зүүнтнүүд мөн оросуудын тулгасныг ёсчлон биелүүлж бурхан шашны 2000 гаруй жилийн турш хэвшсэн уламжлалыг таслан зогсоосон билээ. Энэ бурангуй шийдвэр Монголын түүхэнд анх удаа тохиолдсон учир өргөн олон түмэн ялангуяа лам, хувраг, сүсэгтнүүд маш ихээр цочирдсон ажээ. Энэхүү шийдвэрийн хамгийн гол зорилго бол Монголын бурханы шашны шавь хуврагуудыг нэр хүндтэй удирдагчгүй болгож, цаашдаа шашны бүх

28. УТА. 445-5-44, т.1.

29. Дилав хутагт Б.Жамсранжав. Ариун сэтгэл авралын үндэс. Дуртгал, намтар, өгүүлэл. Хэвлэлд бэлтгэсэн Л.Чойжилсүрэн УБ.2000. т.139.

30. Мөн тэнд.

31. БНМАУ-ын Их бага Хурлын тогтоол, Үндсэн хууль тунхагууд. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Ц. Насанбалжир УБ. 1956, т.89.

байгууллага лам хуврагуудыг ямар ч эсэргүүцэлгүй төлөвлөснөөр устгах боломж бүрдүүлэхэд чиглэж байжээ.

Гэвч ардчилал, шинэчлэл, шүтэж бишрэх эрх чөлөө бодитой хэрэгжих болсон XXI зууны эхээр манай сүсэгтэн хуврагуудын хүсэл эрмэлзлэлийг төрөөс эс хориглосны үрээр Монголын бурхан шашны тэргүүн – IX Богдыг тодруулан залж Монголын сүсэгтэн олны олон жилийн хүслийг биелүүллээ.

Төгсгөл: Цаашид юу хийх вэ?

1926 оны хавраас эхлэн олны анхаарлыг татах болсон Цэнджав хэрхэн яаж тодорсон ба түүний хэрэг гэгчид холбогдогчдын тухай судалгааг улам гүнгийрүүлэхэд анзаарууштай зарим зүйл байгааг судлаачид болон сонирхогчдод сонордуулахыг хичээлээ.

Үүнд:

1. Энэ хэрэг гэгч бол ердийн буюу санамсаргүй тохиолдол бус бололтой. Яагаад гэвэл тухайн үед манай улсын нийт ард иргэд сүсэгтнүүдээс шашны тэргүүн оройн дээд охь манлай Богд Жибзундамбын шинэ дүрийг тодруулахаар хүсэн эрмэлзэж буйг нэр хүндтэй хутагтууд тэргүүлэн төр засагт нэг бус удаа уламжилсан боловч тодорхой хариу сонсоогүй учир олны тусыг бодож Богдын хойд дүр тодорлоо хэмээн төр засагт сануулах арга бодож олсон байж магадгүй юм. Гэвч энэ нь нааштай үр дүнд хүрээгүйгээр үл барам ноцтой гэмт хэрэг болж хувирчээ.

2. Лувсандоржоос гадна Банчин Богдын дэргэдэх бас нэг хөвгүүнийг Богдын хойд дүрээр тодорсон хэмээх сураг сонссон монголчууд Ёнзон хамба Лувсанхаймчигаас асуухад тэрбээр *“чухам тэр нь мөн хэмээн хэлж чадахгүй байсан”*³² тухай мэдээ байдгийг цаашид тун анзаарууштай. Яагаад гэвэл VIII Богдын хойд дүрээр чухам хэдэн хүн тодорсныг гүнзгийрүүлэхэд энэ мэдээ тус дөхөм болно.

3. Зарим хүний тухайлбал Түдэвийнхтэй нэг дор олон жил нутаглаж байсан Ялбагийн цоохор хамниган хэмээх Зундуйсүрэн, Ноён уулын хошууны хамгийн сүүлчийн засаг ноён асан Н.Наваан-Юндэн, эрдэмтэн О.Намнандорж нарын ярьснаар бол Лувсандорж бээр 10 хүрээгүй байхдаа нас нөгчсөн гэх буюу 1947 оны орчим Зүүн Хараагаас цэргийн албанд татагдаад буцаж очоогүй гэнэ лээ гэх зэрэг үнэн худал нь үл мэдэгдэх сураг байдаг. Би бээр 1979 оны зун Намын Түүхийн Институтэд ажиллаж байхдаа ахмад түүхч Б.Цэдэн аругайтай хамт МАХН-ын V Их хурлын баримт бичгийг уйгуржин монгол бичгээс кирилл бичигт буулган хэвлүүлэхээр бэлтгэж байх явцдаа эдгээр хүний яриаг анх сонссон билээ. Мөн Лувсандоржийн эх Цэнджав 1940-өөд оны сүүлч хүртэл нутагтаа байсан ба Түдэв 1937 оны орчим баривчлагдаж, Улаанбаатараас зүүн тийш орших Галтай Булнайд алтан ургийн угсааныхантай цуг ял эдэлж байсан хэмээх сураг бас байдаг.

32. УТА МАН 4-6-8, т.1-112.

4. Цэнджавыг дэмжсэн хэмээн ял сонссон Ёндон хаалгач бээр Гомбо, Балжинням хоёртой цуг оргоогүй нь мэдэгдэж байх боловч хожмоо түүний хувь заяа хэрхсэн нь мэдэгдэхгүй байна. Мөн түүнчлэн түүнийг хэн гэдэг хүнд даалган өгч харгалзуулсан нь ч тодорхойгүй ажээ. Ер нь Цэнджавын хамаатай бүх хэргийг тодруулахын тулд одоогоор төдий л олон хүн нэвтэрч болдоггүй Тагнуулын Ерөнхий Газрын Архив, Засгийн Газрын Архивуудад судалгаа хийх шаардлагатайн сацуу эдгээр архивт хадгалж буй нууцлах хугацаа нь аль эрт дууссан баримтуудыг зохих журмын дагуу судалгааны эргэлтэнд оруулуштайг дашрамд тэмдэглэе.

5. 1937 оны 5-р сарын 25-нд Дотоод явдлын яамнаас хувьсгалын эсэргүү “Төв” хэмээх байгууллагын гишүүдийг мөрдөн байцаасан тухайгаа МАХН-ын Төв Хороонд танилцуулсан мэдээнд “8-р Богд үхсэн ба түүний 9-р дүр буюу шинэ Богдыг залах оролдлого эхэлсэн тухай” хэмээсэн тусгай бүлгийн дотор “Ёндон зурхайч, Балдан гавж, Банзар гавжийн зэрэг нилээд хэдэн этгээдийг 1927-1928 онд баривчлан авч шийтгэсэн”³³ хэмээн дурджээ. Гэтэл эдгээр хүмүүсийг ялласан шүүх хурлын баримт одоогоор олдохгүй байгааг цаашид эрж сурах хэрэгтэй болжээ.

6. Ёндон, Гомбо, Балжинням гурвыг ДХГ баривчилж ял ногдуулсны дараа ч Монголын зарим лам хуврагууд Богдын хойд дүрийг тодруулах байр сууринаасаа няцалгүй нууцаар бэлтгэж байжээ. Тиймээс ч 1931 оны хавар Лувсандоржийг 5 нас хүрэх үед өмнө дурдсан Гэндэнсоном бээр аграмба Гончиг хэмээгчийг Дарьгад нутаглаж буй Түдэвийнх рүү илгээж Богдын хойд дүрийг харж хамгаалж, асарч тойлж, ном зааж бай хэмээн даалгажээ. Гончиг бээр уг ёсоор Лувсандоржийг харж харгалзаж байхад 1934 оны хавар тэр хүү нилээд хүндээр өвчилсөнд жадамба зэрэг ном уншиж, бузар буртгийг нь арилгасан ба тэр хүүг 11 нас хүртэл даахь үсийг нь аваагүй байсан хэмээн улс төрийн хэрэгт баривчлагдсан зарим хүмүүсийн өчиг мэдүүлэгт байна³⁴. Иймд энэ мэтийн үүвэр түүвэр мэдээг олж сайтар судлуштай.

7. Богд хутагтын хойд дүрийг тодруулах эсэх талаар олон жил үргэлжилсэн энэ асуудлыг Монгол эх түүхийн томоохон суурь бүтээлүүдэд товч боловч тусгуштай.

33. УТА, МАН. 4-6-82, т.6-8.

34. УТА, МАН. 4-6-82, т.50-51.

Abstract: This story briefly tells about an incident happened back in 1926 in Mongolia. In the spring of 1926, there was a wide spread rumour that a woman called Tsendjav who lived in the north of Ulaanbaatar gave birth to a boy called Luvsandorj who believed to be a reincarnation of the late Bogdo Jibzundamba, a former monarch of Mongolia. At that time many ordinary people and lamas started to demand from the Mongolian People's Revolutionary Party and the Government of Mongolia to recognize a boy as the reincarnated figure of the Bogdo Jibzundamba and to be enthroned according to the tradition. High rank officials of the Soviet Union have heard about this demand and ordered the Government of Mongolia and its authorities not to acknowledge the reincarnation of the Bogdo Jibzundamba in any circumstance and they acted in accordance with the order from the Soviet Union Government.

Ном зүй

Батсайхан О. Монголын сүүлчийн эзэн хаан наймдугаар Богд

Жавзандамба. Амьдрал ба домог УБ.2011

Гомбосүрэн Д. Хичээнгүй баатар Л.Гомбо-Идшин /1862-1930/ УБ, 2005

Сэсээр З. Хичээнгүй баатар Гомбо-Идшин гүн. Түвэдэд зарагдсан элч
УБ 2005.